



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 дугаар сарын 25 өдөр Дугаар 19

Хэрлэн сум

ХИХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 19 дүгээр хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 86,4 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, төв Номын сан, Музей, Хөгжимт драмын театрын үйл ажиллагааг нээх эсэх талаар хэлэлцэх,

Боловсрол, соёл урлагийн газар

2.Сумдын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг нээхтэй холбогдуулан Хөлөнбуйр сумын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын амрах байрны талаар хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

3.Аймгийн Онцгой комиссын 2021 оны "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд цагийн хязгаарлалт тогтоох тухай" 11 дүгээр тогтоолыг цуцлах эсэх талаар хэлэлцэх,

Цагдаагийн газар

4.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

5.Хилийн Эрэнцав боомтоор шатахуун импортолж буй компаниудтай хийсэн уулзалтын талаар хэлэлцэх,



Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн А.Нансалмаа нарт:

1.1.Ерөнхий боловсролын сургууль, Номын сан, Музей, Хөгжимт драмын театр зэрэг байгууллагуудад халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэхэд хяналт тавих, үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв,

/  / М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

Хоёр.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

2.1.Сумдын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг нээхтэй холбогдуулан Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд байрлаж буй Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын амрах байрны асуудлыг шийдвэрлэх талаар Хөлөнбуйр сумын Засаг дарга, Онцгой комиссын даргад чиглэл өгөхийг,

Гурав.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

3.1.Аймгийн Онцгой комиссын 2021 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд цагийн хязгаарлалт тогтоох тухай” 11 дүгээр тогтоолыг хүчингүй болгож хэвийн горимд шилжүүлэн ажиллахыг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

3.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарлалтыг хүчингүй болгосонтой холбогдуулан согтууруулах ундааны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх, хугацаа дууссан эсэхэд хяналт тавьж ажиллах талаар сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт чиглэл өгөхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

3.3.Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газартай хамтран согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарлалтыг хүчингүй болгосонтой холбогдуулан согтууруулах ундааны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх, хугацаа дууссан эсэхэд хяналт тавьж ажиллахыг,



Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

4.1.Улаанбаатар төмөр замын Баянтүмэн тасгийн удирдлагатай хилийн Эрээнцав боомтод эрсдлийн үнэлгээ хийх чиглэлээр уулзалт зохион байгуулж аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын
орлогч дарга Ч.Ганбат-д:

4.2.Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын бэлтгэл бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийн татагч лебеткыг Онцгой байдлын газар, Баян-Уул, Халхгол сумын Гал түймэр унтраах, аврах 53, 62 дугаар ангиудад тус бүр 1 ширхэг, уснаас эрэн хайх, аврах ажиллагааны усны шумбалтын багаж хэрэгсэл 1 ком, өвөл, зуны хувцас тус бүр 1 ширхэгийг худалдан авах талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн тодотголд санал оруулахыг,

/  / М.Бадамсүрэн
/  Д.Баттулга

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.3.Өвлийн улиралд усны гүний шумбалтыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэсэн Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын усчин аврагч, ахлах ахлагч Н.Нямсүрэнг 300,000 төгрөгөөр шагнах саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, хурандаа Б.Бямбаа,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,

Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал,

Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

4.4.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор Дорнод аймаг халдвар илрээгүй ногоон бүсэд хамаарах тул төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр цаашид ажиллах саналыг аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

